

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2022 /78/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Орхон аймаг 2022 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 7035 9826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 7035 8505 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитор: Л.Баасандорж Утас: 99055703 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр).....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3.Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4. Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал .....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт .....	20
4.1 Залруулсан алдаа .....	20
4.2 Төлбөрийн акт .....	20
4.3 Албан шаардлага .....	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗГНХ	Засгийн Газрын Нөөц Хөрөнгө
ЗДНХ	Засаг Даргын Нөөц Хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол, Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

№ \_\_\_\_\_  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН МУЗЕЙН  
ДАРГА Ч.ЭНХТУЯА ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,912,182.04</b>	<b>12,669,522.04</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	11,912,182.04	12,669,522.04
351	<b>Түүхий эд материал</b>	9,088,718.00	9,276,118.00
35110	Тусгай зориулалттай материал	9,088,718.00	9,276,118.00
354	<b>Хангамжийн материал</b>	2,823,464.04	3,393,404.04
35410	Бичиг хэргийн материал	71,500.00	71,500.00
35420	Аж ахуйн материал	2,002,964.04	2,572,904.04
35450	Барилгын засварын материал	749,000.00	749,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>782,689,056.60</b>	<b>792,101,492.49</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	782,689,056.60	792,101,492.49
392	<b>Биет хөрөнгө</b>	710,729,056.60	720,141,492.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,522,868.25	64,484,368.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,526,912.30)	(46,595,616.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,083,004.97	44,033,934.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,244,604.32)	(35,025,893.88)
39213	Түүх соёл, Музейн дурсгалт зүйлс	692,894,700.00	693,244,700.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	148,300.00	148,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(148,300.00)	(148,300.00)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	71,960,000.00	71,960,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	71,960,000.00	71,960,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>794,601,238.64</b>	<b>804,771,014.53</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>794,601,238.64</b>	<b>804,771,014.53</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>794,601,238.64</b>	<b>804,771,014.53</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	794,601,238.64	174,625,722.48
51101	Өмч: - төрийн	174,625,722.48	174,625,722.48
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	174,625,722.48	54,047,169.26
51210	Өмнөх үеийн үр дүн	43,877,393.37	43,877,393.37
51220	Тайлант үеийн үр дүн	43,877,393.37	10,169,775.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	576,098,122.79
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>794,601,238.64</b>	<b>804,771,014.53</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Код	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>180,459,300.00</b>	<b>164,435,400.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,130,000.00</b>	<b>16,260,500.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32,130,000.00	16,260,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,130,000.00	16,260,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,130,000.00	-
120017	Үнэ төлбөргүй авсан орлого-Үндсэн хөрөнгө		16,204,400.00
120018	Үнэ төлбөргүй авсан орлого-Бараа материал		56,100.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>148,329,300.00</b>	<b>148,174,900.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	437,500.00	872,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	437,500.00	532,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	147,891,800.00	147,302,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,891,800.00	147,302,900.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>155,422,927.48</b>	<b>154,265,624.11</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>155,422,927.48</b>	<b>154,265,624.11</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	136,657,776.84	137,601,540.19
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	98,575,891.70	101,684,186.63
210101	Үндсэн цалин	85,727,525.00	72,756,315.00
210102	Нэмэгдэл	5,955,289.70	28,927,871.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,634,000.00	-
210104	Урамшуулал	1,259,077.00	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,744,452.02	13,082,003.04
210201	Тэтгэврийн даатгал	8,744,379.54	9,041,906.86
210202	Тэтгэмжийн даатгал	862,806.37	1,015,798.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	949,454.30	812,638.77
210204	Ажилгүйдлийн даатгал	199,656.07	201,060.08
210205	Эрүүл мэндийн даатгал	1,988,155.74	2,010,598.74
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,420,505.64	6,440,466.41
210301	Гэрэл, цахилгаан	1,089,393.41	695,066.82
210302	Түлш, халаалт	5,417,882.98	5,285,651.00
210303	Цэвэр, бохир ус	913,229.25	459,748.59
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,993,762.00	3,159,420.00
210401	Бичиг хэрэг	904,300.00	864,610.00
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	280,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,000.00	664,460.00
210404	Ном, хэвлэл	-	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,223,000.00	1,250,350.00
210408	Бараа материал акталсны зардал	1,822,462.00	-
2105	<b>Нормативт зардал</b>	371,600.00	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	371,600.00	150,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	579,300.00	108,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	121,800.00	8,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	265,000.00	-
210604	Урсгал засвар	192,500.00	100,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	82,000.00	210,000.00
210702	Дотоод албан томилолт	82,000.00	210,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,019,700.00	5,974,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,760,000.00	4,715,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210807	Газрын төлбөр	539,700.00	539,700.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,870,565.48	6,791,964.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,870,565.48	6,791,964.11
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18,765,150.64	16,664,083.92
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	700,000.00	12,392,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	12,392,800.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	18,065,150.64	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,065,150.64	-
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	4,271,283.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,271,283.92
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>25,036,372.52</b>	<b>10,169,775.89</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>25,036,372.52</b>	<b>10,169,775.89</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>148,329,300.00</b>	<b>148,174,900.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>148,329,300.00</b>	<b>148,174,900.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	437,500.00	872,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	437,500.00	532,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	147,891,800.00	147,302,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,891,800.00	147,302,900.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>148,329,300.00</b>	<b>148,174,900.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>148,329,300.00</b>	<b>148,174,900.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>129,564,149.36</b>	<b>131,510,816.08</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	98,575,891.70	101,684,186.63
210101	Үндсэн цалин	85,727,525.00	72,756,315.00
210102	Нэмэгдэл	12,848,366.70	28,927,871.63
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,744,452.02	13,082,003.04
210201	Тэтгэврийн даатгал	8,706,845.42	9,041,908.36
210202	Тэтгэмжийн даатгал	855,720.40	1,015,798.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	991,906.53	812,638.58
210204	Ажилгүйдлийн даатгал	380,470.87	201,059.77
210205	Эрүүл мэндийн даатгал	1,809,508.80	2,010,598.24
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,420,505.64	6,440,466.41
210301	Гэрэл, цахилгаан	1,089,393.41	695,066.82
210302	Түлш, халаалт	5,417,882.98	5,285,651.00
210303	Цэвэр, бохир ус	913,229.25	459,748.59
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,171,300.00	3,341,660.00
210401	Бичиг хэрэг	904,300.00	805,410.00
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	280,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,000.00	741,460.00
210404	Ном, хэвлэл	-	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,223,000.00	1,414,790.00
2105	<b>Нормативт зардал</b>	371,600.00	371,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	371,600.00	371,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,178,700.00	361,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	721,200.00	261,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	265,000.00	-
210604	Урсгал засвар	192,500.00	100,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	82,000.00	210,000.00
210702	Дотоод албан томилолт	82,000.00	210,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,019,700.00	6,019,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,760,000.00	4,760,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210807	Газрын төлбөр	539,700.00	539,700.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,765,150.64</b>	<b>16,664,083.92</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	700,000.00	12,392,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	11,692,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалт	700,000.00	700,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	18,065,150.64	4,271,283.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,065,150.64	4,271,283.92
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.00	0.00
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.00	0.00
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.00	0.00
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	0.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	0.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	174,625,722.48	576,098,122.79	18,841,020.85	769,564,866.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	174,625,722.48	576,098,122.79	18,841,020.85	769,564,866.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	25,036,372.52	25,036,372.52
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>174,625,722.48</b>	<b>576,098,122.79</b>	<b>43,877,393.37</b>	794,601,238.64
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>174,625,722.48</b>	<b>576,098,122.79</b>	<b>43,877,393.37</b>	794,601,238.64
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	10,169,775.89	10,169,775.89
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>174,625,722.48</b>	<b>576,098,122.79</b>	<b>54,047,169.26</b>	804,771,014.53

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %-аар
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	147,302,900.00	143,031,616.08	4,271,283.92	97.1
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	147,302,900.00	143,031,616.08	4,271,283.92	97.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	135,110,100.00	130,838,816.08	4,271,283.92	96.8
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	101,830,600.00	101,684,186.63	146,413.37	99.9
210101	Үндсэн цалин	84,621,800.00	72,756,315.00	11,865,485.00	86.0
210102	Нэмэгдэл	17,208,800.00	28,927,871.63	11,719,071.63	168.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,747,100.00	13,082,003.04	665,096.96	95.2
210201	Тэтгэврийн даатгал	9,673,900.00	9,041,908.36	631,991.64	93.5
210202	Тэтгэмжийн даатгал	1,018,300.00	1,015,798.09	2,501.91	99.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	814,600.00	812,638.58	1,961.42	99.8
210204	Ажилгүйдлийн даатгал	203,700.00	201,059.77	2,640.23	98.7
210205	Эрүүл мэндийн даатгал	2,036,600.00	2,010,598.24	26,001.76	98.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,082,400.00	6,440,466.41	2,641,933.59	70.9
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	695,066.82	1,304,933.18	34.8
210302	Түлш, халаалт	4,778,400.00	5,285,651.00	507,251.00	110.6
210303	Цэвэр, бохир ус	2,304,000.00	459,748.59	1,844,251.41	20.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,812,200.00	2,809,660.00	2,540.00	99.9
210401	Бичиг хэрэг	605,200.00	605,200.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	240,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,000.00	741,460.00	2,540.00	99.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,223,000.00	1,223,000.00	-	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	371,600.00	371,600.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	371,600.00	371,600.00	-	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	221,200.00	221,200.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	221,200.00	221,200.00	-	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	265,000.00	210,000.00	55,000.00	79.2
210702	Дотоод албан томилолт	265,000.00	210,000.00	55,000.00	79.2
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,780,000.00	6,019,700.00	760,300.00	88.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,760,000.00	4,760,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	800,000.00	539,700.00	260,300.00	67.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	-	500,000.00	0.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	12,192,800.00	12,192,800.00	-	100.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	12,192,800.00	12,192,800.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,692,800.00	11,692,800.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.0
1320	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	147,302,900.00	143,031,616.08	4,271,283.92	97.1
132001	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	147,302,900.00	143,031,616.08	4,271,283.92	97.1
132001	Орон нутгийн төсвөөс	147,302,900.00	143,031,616.08	4,271,283.92	97.1
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	0.00	0.00	0.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	0.00	0.00	0.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	-
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	9	9	-	-
620001	Удирдах ажилтан	1	1	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6	-	-
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	2021.12.31
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>872,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>872,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	672,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	532,000.00
210401	Бичиг хэрэг	200,210.00
210402	Тээвэр, шатахуун	40,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	191,790.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	140,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,000.00
210604	Урсгал засвар	100,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	200,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	872,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	872,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	532,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>0.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд урамшуулалт цалин хөлс, төсвийн зарцуулалт, хөрөнгийн ангилалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Баасандорж гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэгч талаас тус компанийн чанарын хяналтын менежер М.Бямбадорж, захирал Б.Байгал нар, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Музей нь орон нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалан, сурталчлах, түүх соёлоороо бахархах үзлийг ирээдүй хойч үе, иргэдэд төлөвшүүлэх зорилгоор түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах, судлан сурталчлах, нийтийн хүртээл болгох, түгээн дэлгэрүүлэх чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Музейн тухай хууль зэрэгт 2021 онд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Орхон аймгийн Музей нь ССАЖ-ын сайдын 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/378 тоот тушаал “Журам батлах тухай”-ын хавсралт “Музейн байгууллагад дотоодын хяналт шалгалт зохион байгуулах журам”, байгууллагын захирлын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Орхон аймгийн Музейн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журам” зэргийг дотоод хяналтын үйл ажиллагаандаа дагаж мөрддөг. 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/04 тоот тушаал “Дотоод хяналт шалгалтын нэгж ажилтан томилох тухай”-аар Бүртгэл мэдээллийн санч Г.Гансоёмбыг томилж ажиллуулсан байна.

Дотоод хяналтын ажилтан 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Музейн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг 8 бүлэг, 48 чиглэлээр хийхээр батлуулж, тайлант хугацаанд дотоод хяналт шалгалтын бүлэг, чиглэлээр дэд

төлөвлөгөө, ажлын удирдамж боловсруулан батлуулж, дотоод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэжээ. Үүнд, байгууллагын эрдэм шинжилгээний ажилд 1 удаа, Музейн тайлбарлагчийн үйл ажиллагаанд 3 удаа, Сан хөмрөгчийн үйл ажиллагаанд 3 удаа, санхүү, нярвын үйл ажиллагаанд 1 удаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд 1 удаа зэрэг болно. Дотоод хяналт шалгалтаар санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хангалттай сайн гэж дүгнэжээ.

Түүнчлэн Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 оны 3 дугаар сар, 10 дугаар саруудад байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд уг шалгалтаар тогтмол зардлын хяналтыг сайжруулж, тоолуур тавих зөвлөгөө өгснийг хэрэгжүүлж ажилласан байна. Бусад үйл ажиллагааг эрсдэлгүй гэж дүгнэжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоон тооцсон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 147,302.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2,946.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,062.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд төсвийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөлтийн үед сонгон авсан хувь хэмжээ, гүйцэтгэл тооцох хувийг ашиглан материаллаг байдлыг шинэчлэн тогтооход 2.4%-аар буюу 68.0 мянган төгрөгөөр буурсан тул АДБОУС-д тодорхойлсны дагуу материаллаг байдлыг 2,014.6 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,169.8 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Авлага	-	-	-	-
Урьдчилгаа	-	-	-	-
Бараа материал	11,912.2	12,669.5	757.3	6.4
Үндсэн хөрөнгө	782,689.0	792,101.5	9,412.4	1.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>794,601.2</b>	<b>804,771.0</b>	<b>10,169.8</b>	<b>1.3</b>
Өр төлбөр	-	-	-	-
Засгийн газрын оролцоо	794,601.2	804,771.0	10,169.8	1.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмч</b>	<b>794,601.2</b>	<b>804,771.0</b>	<b>10,169.8</b>	<b>1.3</b>

Тус байгууллага нь Төрийн санд үндсэн болон нэмэлт санхүүжилтийн 2 данстай болно.

Үндсэн санхүүжилтийн харилцах 100210035010 тоот дансаар 147,302.9 мянган төгрөгийн орлого орж, зарцуулагдсан байна. Энэ нь 100% орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого байна. Үүнээс 143,031.6 мянган төгрөг урсгал үйл ажиллагаанд зарцуулагдаж, 4,271.3 мянган төгрөг нь төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн 100210035405 тоот дансаар 872.0 мянган төгрөгийн мөнгөн орлого орж зарцуулагджээ. Уг орлого нь ЗДНХ-өөс үзэсгэлэн зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн 340.0 мянган төгрөг, байгууллагын төлбөртэй үйлчилгээнээс орсон 532.0 мянган төгрөгийн орлогоос бүрдэж байна. Нэмэлт төсвөөр орж ирсэн мөнгөн орлогыг урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Тайлант онд тус байгууллага нь авлага үүсгэж бүртгэж тайлагнаагүй бөгөөд үлдэгдэлгүй байна.

Харин тайлант онд 33,300.3 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгогдож буцаан суутгагдсанаар урьдчилж гарсан зардал үлдэгдэлгүй толилуулагдсан байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 6.4%-аар буюу 757.3 мянган төгрөгөөр өссөн байна. Уг өсөлтөд дараах бараа материалуудын хөдөлгөөн нөлөөлсөн байна. Үүнд:

- Тусгай зориулалтын материал тайланд онд өмнөх оноос 2.1%-аар буюу 187.4 мянган төгрөгөөр өссөн бөгөөд энэ 187.4 мянган төгрөгийн шат худалдан авсантай холбоотой байна. Уг хөрөнгөөс тайлант онд зарцуулагдаагүй байна.
- Бичиг хэргийн материалд тайлант онд өсөлт, бууралт гараагүй бөгөөд төсвийн хөрөнгөөр тайлант онд 844.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч, бүгдийг нь бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.
- Аж ахуйн материал өмнөх оноос 28.5%-аар буюу 569.9 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 56,1. Мянган төгрөгийн музейн үзвэрийн билетийг дотооддоо хэвлэж үйлдвэрлэн орлогоор хүлээн зөвшөөрч, буцаан зарцуулсан байна. Харин төсвийн хөрөнгөөр 2,874.2 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч 100.0 мянган төгрөгийг ном, хэвлэлийн зардалд, 1,250.3 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлсийн зардалд, 150.0 мянган төгрөгийг нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд, 410.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд, 450.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд тус тус зарцуулсан зэрэг нь нөлөөлжээ.
- Тайлант хугацаанд 280.0 мянган төгрөгийн түлш, шатахууныг төсвийн хөрөнгөөр худалдан авч, бүгд тээвэр, шатахууны зардалд зарцуулагдаж, үлдэгдэлгүй тайлагнагджээ.
- Барилгын засварын материалын үлдэгдэлд тайланд онд өөрчлөлт ороогүй, харин тайлант онд 108.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 8.8 мянган төгрөгийг багаж, техник хэрэгслийн зардалд, үлдсэнийг нь урсгал засварын зардалд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1.2%-аар буюу 9,412.4 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд дараах хөрөнгүүдийн хөдөлгөөн, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал зэрэг нөлөөлсөн байна.

- Тайлант онд машин тоног төхөөрөмж дансанд дараах хөдөлгөөн гарч, түүхэн өртөг, хуримтлагдсан элэгдэл, дансны үнэд нөлөө үзүүлсэн байна. 2021 онд бүртгэл мэдээллийн сангийн компьютер, тоног төхөөрөмж, Virtual reality төхөөрөмж, Epson L3150 өнгөт принтер, 64VGX Garmin GPS, камерын санах ойн төхөөрөмж болох хард диск зэрэг 5 нэр төрлийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 14,200.0 мянган төгрөгийн хөрөнгө, Соёлын яамны хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 1,654.4 мянган төгрөгийн зөөврийн компьютер, нийт 15,854.4 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж нэмэгдсэн байна. Харин Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/165 дугаар захирамжийн дагуу элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан теле хяналтын камер, дижитал аппарат, чийгшүүлэгч аппарат, галын хор зэрэг 4 нэр төрлийн 6,892.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг акталсан байна. Тайлант онд уг бүлэг хөрөнгөд 2,961,6 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан бөгөөд эдгээрийн үр нөлөөгөөр машин тоног төхөөрөмжийн түүхэн өртөг 8,961.5 мянган төгрөг буюу 16.1%-аар өссөн, хуримтлагдсан элэгдэл 3,931.3 мянган төгрөг буюу 7.8%-аар буурсан, дансны үнэ 12,892.8 мянган төгрөгөөр буюу 258.1%-аар өссөн байна.

- Тайланд онд шинээр тавилга, эд хогшил нэмж худалдан аваагүй, харин Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/165 дугаар захирамжийн дагуу элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 2 ширхэг ус буцалгагч болох 47.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна, Уг бүлэг хөрөнгөд тайлант онд 3,830.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар тоног төхөөрөмжийн түүхэн өртөг 49.1 мянган төгрөг буюу 0.1%-аар буурсан, хуримтлагдсан элэгдэл 3,781.3 мянган төгрөг буюу 12.1%-аар өссөн, дансны үнэ 3,830.3 мянган төгрөгөөр буюу 29.8%-аар буурсан байна.
- Түүх соёл, музейн дурсгалт зүйлс тайлант онд 350.0 мянган төгрөгөөр буюу 0.1%-аар өссөн бөгөөд энэ нь зэс данх, шаазан ваар, ил уурхайн гэрэл зураг, анчин Хавделын уран зураг зэрэг 4 төрлийн үзмэрийг захирлын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/11 тоот тушаалаар үнэлж, орлогод авсантай холбоотой байна.
- Бусад эргэлтийн бус хөрөнгө болох 148.3 мянган төгрөгийн хөрөнгө (хивс)-д хөдөлгөөн гараагүй, элэгдэл байгуулагдаагүй байна.
- Тус байгууллага нь 71,960.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхтэй бөгөөд уг хөрөнгөд тайлант онд хөдөлгөөн гараагүй байна.

Тайлант онд өр төлбөргүй ажиллаж, өр төлбөрийн данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна. 2021 онд цалингийн 101,684.2, НДШ-ийн 23,320.7 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 6,617.6 мянган төгрөгийн, шуудан холбооны 664.6 мянган төгрөгийн, гэрэл цахилгааны 695.1 мянган төгрөгийн, түлш халаалтын 5,285.6 мянган төгрөгийн, цэвэр, бохир усны 459.7 мянган төгрөгийн, тээвэр шатахууны 280.0 мянган төгрөгийн, бусад урсгал зардалтай холбоотой байгууллагад өгөх 11,593.2 мянган төгрөгийн, хувь хүмүүст өгөх 14,430.5 мянган төгрөгийн өр төлбөрүүд үүсэж, бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 10,169.8 мянган төгрөгөөр буюу 1.3%-аар өсөж 804,771.0 мянган төгрөг болжээ. Үүнд тайлант үеийн үр дүн 10,169.8 мянган төгрөгөөр өссөнөөр хуримтлагдсан үр дүн өссөн нь нөлөөлжээ. Төрийн өмчид өөрчлөлт ороогүй байна.

Орлогын нэр төрөл	Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/			
	2020	2021	Өөрчлөлт	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	147,891.8	147,302.9	(588.9)	(0.4)
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	340.0	340.0	100.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,130.0	16,260.5	(15,869.5)	(49.4)
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	437.5	532.0	94.5	21.6
<b>Нийт орлого</b>	<b>180,459.3</b>	<b>164,435.4</b>	<b>(16,023.9)</b>	<b>(8.9)</b>

2021 онд тус байгууллагын нийт орлого өмнөх оноос 16,023.9 мянган төгрөгөөр буюу 8.9%-аар буурсан байна. Үүнд, урсгал үйл ажиллагааны зардлын санхүүжилт 588.9 мянган төгрөгөөр буюу 0.4%-аар, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 15,869.5 мянган төгрөг буюу 49.4%-аар буурч, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 340.0 мянган төгрөгөөр буюу 100%, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 94.5 мянган төгрөгөөр буюу 21.6%-аар тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүнийг орлогын нэр төрөл тус бүрээр шинжилбэл дараах байдалтай байна. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 0.4%-аар буюу 588.9 мянган төгрөгөөр буурсан нь 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 тоот тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"-ын дагуу урсгал санхүүжилт өмнөх оноос буурч батлагдсантай холбоотой байна.
- Өмнөх онд туслах үйл ажиллагаанаас 437.5 мянган төгрөг олж байсан бол тайлант онд 532.0 болж өссөн нь цар тахлын сөрөг үр нөлөө буурч, соёлын байгууллагуудын үйл ажиллагааг тайланд онд тодорхой хугацаанд нээж, музейн үзмэрийн үйлчилгээ, үзэсгэлэн зохион байгуулж иргэдэд үйлчилгээ үзүүлсэн зэрэгтэй холбоотой байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого тайлант онд өмнөх оноос 15,869.5 мянган төгрөгөөр буюу 49.4%-аар буурсан дараах нөлөөтэй байна. Үүнд:

*Хүснэгт 3. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын үзүүлэлт /мянган төгрөг/*

Нийлүүлэгч	Санхүүжилтийн эх үүсвэр	Орлогын төрөл	Төрөл	2020	2021	Өөрчлөлт	Хувь
Шижир бумба ХХК	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Үндсэн хөрөнгө	Машин тоног төхөөрөмж	-	14,200.0	14,200.0	100.0
Бодь электроникс	Соёлын яамны хөрөнгө оруулалт	Үндсэн хөрөнгө	Машин тоног төхөөрөмж	-	1,654.4	1,654.4	100.0
Орхон аймгийн музей	Бусад эх үүсвэр	Үндсэн хөрөнгө	Түүх соёл, музейн дурсгалт зүйл	32,130.0	350.0	(31,780.0)	(98.8)
		Бараа материал	Аж ахуйн материал	-	56.1	56.1	100.0
<b>ДҮН</b>				<b>32,130.0</b>	<b>16,260.5</b>	<b>(15,869.5)</b>	<b>(49.4)</b>

Дээрх үнэ төлбөргүй орлогоос түүх соёл, музейн дурсгалын зүйл нь өмнөх онд “Айргийн гозгор” төслийн эрэл хайгуулын үр дүнд бий болсон эд өлгийн болон бусад дурсгалын зүйл, гаалийн байгууллагад хураагдсан шашны судар, үзмэрүүдийг үнэлж орлогод авсантай холбоотой бол тайлант онд орлогод авсан зүйл нь хандивлагч иргэдийн өгсөн музейн нөөц санд байсан хөрөнгийн үнэлж орлогод авсантай холбоотой байна.

- Энэ онд музейн үйл ажиллагааг түшиглэн “Маркт мөнхөрсөн Монгол мину” үзэсгэлэнг зохион байгуулахтай холбоотойгоор ЗДНХ-өөс 340.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

*Хүснэгт 4. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	2020	2021	Өөрчлөлт	Хувь
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>155,422.9</b>	<b>154,265.6</b>	<b>(1,157.3)</b>	<b>(0.7)</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>155,422.9</b>	<b>154,265.6</b>	<b>(1,157.3)</b>	<b>(0.7)</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>136,657.8</b>	<b>137,601.5</b>	<b>943.8</b>	<b>0.7</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,575.9	101,684.2	3,108.3	3.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,744.5	13,082.0	337.6	2.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,420.5	6,440.5	(980.0)	(13.2)
Хангамж, бараа материалын зардал	4,993.8	3,159.4	(1,834.3)	(36.7)
Нормативт зардал	371.6	150.0	(221.6)	(59.6)
Эд хогшил, урсгал засварын зардал	579.3	108.8	(470.5)	(81.2)
Томилолт, зочны зардал	82.0	210.0	128.0	156.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,019.7	5,974.7	(45.0)	(0.7)
Бараа үйлчилгээний бусад зардал	5,870.6	6,792.0	921.4	15.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,765.2</b>	<b>16,664.1</b>	<b>(2,101.1)</b>	<b>(11.2)</b>
Бусад урсгал шилжүүлэг	700.0	12,392.8	11,692.8	1,670.4
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,065.2	-	(18,065.2)	(100.0)
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,271.3	4,271.3	100.0

Нийт зардал өмнөх оноос 0.7%-аар буюу 1.157.3 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант он үйл ажиллагааны бус зардал гараагүй байна. Үйл ажиллагааны зардлын бууралтад бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлт 0.7%-аар буюу 943.8 мянган төгрөгөөр өсөж, урсгал шилжүүлэг 11.2%-аар буюу 2,101.1 мянган төгрөгөөр буурсан зэрэг нь нөлөөлсөн байна. Үүнд:

- ✓ Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд ажилчдын цалин хөлс 3.2%-аар буюу 3,108.3 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 2.6%-аар буюу 337.6 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 156.1%-аар буюу 128.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 15.7%-аар буюу 921.4 мянган төгрөгөөр тус тус өсөж тогтмол зардал 13.2%-аар буюу 980.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 36.7%-аар буюу 1,834.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 81.2%-аар буюу 470.5 мянган төгрөгөөр, нормативт зардал 59.6%-аар буюу 221.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 0.7%-аар буюу 45.0 мянган төгрөгөөр тус тус буурсан зэрэг нөлөөлсөн байна.
- ✓ Урсгал шилжүүлгийн зардлын бууралтад бусад урсгал шилжүүлэг өмнөх оноос 1,670.4% буюу 11,692.8 мянган төгрөгөөр өссөн, улсын төсвийн төвлөрүүлэх урсгал шилжүүлэг өмнөх оноос 100%-аар буюу 18,065.2 мянган төгрөгөөр буурсан, Орон

нутгийн төсвийн урсгал шилжүүлэг өмнөх оноос 100% буюу 4,271.3 мянган төгрөгөөр өссөн зэрэг нь нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын хувь оролцооны нийт дүн 10,169.8 мянган төгрөгөөр буюу 1.3%-аар өссөн нь тайлант оны үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийг хийхдээ өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд суурилан өмнөх жилүүдэд уламжлагдан ирсэн төсвийн төсөл зохиох MS-Excel программд тулгуурласан маягт аргачлалын дагуу боловсруулж, байгууллагын захиралд танилцуулан санал, зөвлөмжийг тусган эцэслэсний дараа төсвийн саналыг Төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд Орхон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэнд боловсруулж хүргүүлдэг бөгөөд уг төсвийн төсөл Орхон аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэгдэн батлагдаж, Санхүү төрийн сангийн хэлтсээр дамжуулагдан байгууллагад хүргэгдэж ирдэг. Төсвийн төслийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан жил бүр шинэчлэн хүргүүлдэг боловч байгууллагын санал тэр бүр тусгагддаггүй, өмнөх жилийн төсвөөс материаллаг зөрүүгүй батлагдаж ирдэг байна.

Батлагдсан төсвийн зарлага болох 147,302.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр баталжээ. Тайлант хугацаанд Орхон аймгийн Музейн батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын 2021 оны төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 2021 оны байдлаар 147,302.9 мянган төгрөг болж батлагдсан төсвийн дүн өмнөх оны төлөвлөгөөнөөс 0.4%-аар буюу 558.9 мянган төгрөгөөр буурсан бол 2021 оны анхны батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна. Эдгээртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 5-д үзүүлэв.

*Хүснэгт 5 Төсвийн төлөвлөлтийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/*

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төсвийн төлөвлөлт			2020/2021 оны зөрүү	Хувь	2021 оны тодотгол зөрүү	Хувь
		2020 оны төсвийн төлөвлөгөө	2021 оны анхны батлагдсан төлөвлөгөө	2021 оны батлагдсан төлөвлөгөө				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,891.80	147,302.90	147,302.90	(588.90)	-0.4	-	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,391.80	135,110.10	135,110.10	(12,281.50)	-8.3	-	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,830.60	101,830.60	101,830.60	(8,000.00)	-7.3	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,728.80	13,747.10	13,747.10	18.30	0.1	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,082.40	9,082.40	9,082.40	(3,000.00)	-24.8	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,112.20	2,812.20	2,812.20	(300.00)	-9.6	-	-
2105	Нормативт зардал	371.60	371.60	371.60	-	0.0	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,021.20	221.20	221.20	(800.00)	-78.3	-	-
2107	Томилолт, зочны зардал	465.00	265.00	265.00	(200.00)	-43.0	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,780.00	6,780.00	6,780.00	-	0.0	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500.00	12,192.80	12,192.80	11,692.80	2338.6	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	500.00	12,192.80	12,192.80	11,692.80	2338.6	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	147,891.80	147,302.90	147,302.90	(588.90)	-0.4	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	147,891.80	147,302.90	147,302.90	(588.90)	-0.4	-	-

Дээрх төсвийн төлөвлөлтийн өөрчлөлтөд үзүүлсэн нөлөөллийн хүчин зүйлүүдийг тайлбарлан авч үзвэл дараах байдалтай байна. Тайлант онд нормативт зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд өөрчлөлт

ороогүйгээр, урсгал шилжүүлгийн зардлаас бусад урсгал зардал буурч батлагдсан байна. Энэ нь 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 тоот тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой болно.

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, Ажил олгогчоос төлөх НДШ: Тайлант онд өмнөх оноос цалин хөлс 8,000.0 төгрөгөөр буюу 7.3%-аар буурч, НДШ-ийн зардал 18.3 мянган төгрөгөөр буюу 0.1%-аар өсөж батлагдсан байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Өмнөх оноос 3,000.0 мянган төгрөгөөр буюу 24.8%-аар буурч батлагдсан байна.
- Хангамж, бараа материалын зардал: Өмнөх оноос 300.0 мянган төгрөгөөр буюу 9.6%-аар буурч батлагдсан байна.
- Нормативт зардал: Энэ зардал өмнөх оны дүнтэй ижил дүнгээр батлагдсан байна.
- Эд хогшил, урсгал засварын зардал: Өмнө оны батлагдсан төсвөөс 800.0 мянган төгрөгөөр буюу 78.3%-аар буурч батлагдсан байна.
- Томилолт, зочны зардал: Өмнөх оны төсвөөс 43.0%-аар буюу 200.0 мянган төгрөгөөр бага төсөвлөгдсөн батлагдсан байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж: Өмнөх оноос өөрчлөлт ороогүй батлагджээ.
- Урсгал шилжүүлэг зардал: Өмнөх оны батлагдсан төсвөөс 11,692.8 мянган төгрөгөөр өсөж батлагдсан бөгөөд энэ 1 ажилчин тэтгэвэрт гарахтай холбоотой тэтгэмжийг төсөвлөсөнтэй холбоотой юм.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 147,302.9 мянган төгрөгийн төсөв баталж орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 143,031.6 мянган төгрөг буюу 97.1% байна. Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзлийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6 Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт /мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	147,302.9	143,031.6	4,271.3	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,302.9	143,031.6	4,271.3	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	135,110.1	130,838.8	4,271.3	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,830.6	101,684.2	146.4	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,747.1	13,082.0	665.1	95.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,082.4	6,440.5	2,641.9	70.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,812.2	2,809.7	2.5	99.9
2105	Нормативт зардал	371.6	371.6	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	221.2	221.2	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	265.0	210.0	55.0	79.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,780.0	6,019.7	760.3	88.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,192.8	12,192.8	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,192.8	12,192.8	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	147,302.9	143,031.6	4,271.3	97.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	147,302.9	143,031.6	4,271.3	97.1

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 146.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 665.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2,641.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 2.5 мянган төгрөг, томилолт, зочны зардлаас 55.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжаас 760.3 мянган төгрөг хэмнэж, батлагдсан төсвөөс орон нутгийн төсөвт 4,271.3 мянган төгрөг татан төвлөрүүлсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах заалтад “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 340.0 мянган төгрөгийг “Маркт мөнхөрсөн Монгол мину” үзэсгэлэн зохион байгуулахад зориулж санхүүжилт олгосон бол байгууллагын төлбөртэй ажил үйлчилгээний орлогоос 532.0 мянган төгрөг олж төсөвт төвлөрүүлэн нэмэлт төсвөөс буцаан бичиг хэргийн зардалд 200.2 мянган төгрөг, тээвэр, шатахууны зардалд 40.0 мянган төгрөг, ном, хэвлэлийн зардалд 100.0 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 191.8 мянган төгрөг, багаж, техник, хэрэгслийн зардалд 40.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 100.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 200.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

#### Үндсэн хөрөнгийн дараа үеийн хэмжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй 40,440.1 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй, 45 нэр төрлийн 50 ширхэг машин тоног төхөөрөмж, 7,334.7 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй, 21 нэр төрлийн 58 ширхэг тавилга, эд хогшил, 148.3 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй, 1 нэр төрлийн 1 ширхэг бусад эргэлтийн бус хөрөнгө байгууллагын хяналтад оршиж, ашиглагдсаар байна.

УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ийн 44 дугаар параграф “хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Тайлангийн өдрөөрх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг хянан магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино.”, 49 дүгээр параграф “Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллаг өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байдаг”, 51 дүгээр параграф “хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлэх бол тухайн хөрөнгийн харьяалагдаж буй үндсэн хөрөнгийн нийт ангийг дахин үнэлнэ” гэж тус тус заажээ. Стандартын дээрх заалтуудаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил гэсэн хөрөнгийн ангид байгаа хөрөнгүүдийн дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ материаллаг ялгаатай үед тухайн ангид байгаа бүх хөрөнгийг дахин үнэлэхийг шаардаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 дугаарт “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасан байна.

Эдгээр стандарт болон хуулийн заалтуудад нийцүүлэн дээрх хөрөнгүүдийг үндсэн хөрөнгийн ангиар нь дахин үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгах бодит хэрэгцээ, шаардлага байгааг бүх шатны төсвийн захирагч нар анхаарах нь зүйтэй юм.

#### *Тасралтгүй байх зарчим*

Тус байгууллага нь 2021 онд Орхон аймгийн орон нутгийн төсвөөс санхүүждэг орон нутгийн төсвийн байгууллагын статустай үйл ажиллагаа явуулж ирсэн бол 2022 оноос Соёлын яам, түүний харьяа Орхон аймаг дахь Соёлын хэлтэст харьяалагдаж үйл ажиллагаагаа явуулах төсөөлөлтэй байна. Гэхдээ байгууллагын үйл ажиллагаа цаашид тасралтгүй үргэлжлэх тул энэ нь АОУС 570 “Тасралтгүй байх зарчим”-тай зөрчилдөж буй асуудал биш юм.

Эдгээр асуудалтай холбоотойгоор бидний дүгнэлт хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Бидний гүйцэтгэж буй санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал, толилуулгад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал тохиолдоогүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг авч үзвэл, тайлант хугацаанд оруулбал зохих 121 мэдээллээс хугацаандаа оруулсан 113, хоцроож мэдээлсэн 4, хугацаа болоогүй 4 мэдээлэл байна.

Шилэн дансны хэрэгжилтэд тайлант оны 1, 2, 3 дугаар улиралд Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалтыг зохион байгуулсан бөгөөд харгалзан 100%, 100%, 97.4%-тай дүгнэгдсэн байна.

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 дахь заалт “*тогтсон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх*”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “*Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журам*”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь хугацаа хоцроож мэдээлсэн 4 мэдээллийг эс тооцвол Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтууд нийцсэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаж байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитын явцад бусад хууль тогтоомжийн хүрээнд хөндөгдөхүйц нийцлийн аудитын асуудал ажиглагдаагүй болно.

Тиймээс шилэн дансны хэрэгжилт болон энэхүү тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 100% хувьтай байна.

*Хүснэгт 7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1		1		-		-
Зөвлөмж	1		1		-		-
Нийт дүн	2		2		-		-

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 17 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

#### **Бараа материалын ангилалтай холбоотой асуудал**

Бид аудитаар тус байгууллагын бараа материалаарх хөрөнгийн үлдэгдэлд ажиглалт, шинжилгээний горим хэрэгжүүлэхэд хөрөнгүүдийн ангилал зөрүүтэй байна. Аудитын цаг хугацааны хязгаарлалтаас үүдэн уг алдаа нь залруулагдаагүй тул дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,832.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, материаллаг шинжтэй 1,611.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, материаллаг бус 220.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа байхгүй залруулга хийгдээгүй.

#### **4.2 Төлбөрийн акт**

Бидний гүйцэтгэсэн аудитаар горим, сорилоор тус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналд төлбөрийн акт тогтоох түвшний материаллаг алдаа, зөрчил илэрхийлэгдээгүй болно.

#### **4.3 Албан шаардлага**

##### **1. Цалин хөлстэй холбоотой асуудал**

Монгол улс 2021 оны төсвийн жилд хэмнэлтийн горимд шилжүүлэх Засгийн газрын тогтоол гарсаар байтал энэ оны хэмнэгдсэн цалингийн зардлаас ажилтан албан хаагчдад 1,611,901 төгрөгийн урамшуулалт цалин олгогдсон байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын 1.3 дахь заалт “. . . цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, . . .” гэсэнтэй нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Цалингийн зардлаас НДШ-ийн зардал руу 28.3 мянган төгрөгийг холбогдох тушаал шийдвэргүйгээр гүйлгэн зарцуулсан байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6 дахь заалтыг мөрдөж ажиллах

##### **2. Хөрөнгийн ангилалтай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Бараа материал оновчтой ангилагдаагүй, тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалыг дэд ангилал үүсгэн бүртгээгүй байна. Мөн үндсэн хөрөнгийн бусад үндсэн хөрөнгөд хамаарах 1 нэр төрлийн 1 ширхэг, 148.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгө, тавилга эд хогшил бүлэг хөрөнгөд бүртгэлтэй 4 нэр төрлийн 5 ширхэг, 79.8 мянган төгрөгийн хөрөнгүүдийн ангилал буруу байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “Журам батлах тухай”-ын 1 дүгээр хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.16, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай”-ын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС 12 “Бараа материал”, УСНББОУС №17 “Үндсэн хөрөнгө” зэрэг хууль эрх зүйн болон стандартад нийцүүлэн хөрөнгийг дахин ангилах, дансны дэд ангилал үүсгэх

**3. Цалин хөлстэй холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд ажилчдын цалин хөлсийг нийгмийн даатгалд дутуу тайлагнасантай холбоотой 47.7 мянган төгрөгийн НДШ дутуу тайлагнагдсан, цалин хөлс тооцох санхүүгийн программын өөрчлөлттэй холбоотойгоор тооцооллын 144.8 мянган төгрөгийн алдаа гаргаж, татварын байгууллагад 85.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад 21.8 мянган төгрөг, ажиллагсад 37.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7 дахь заалтад заасны дагуу цалин хөлсний тооцоололтой холбоотой татвар, шимтгэлийг зөв тооцоолж, хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Музей	4	1,832.7	-	-	-	-	1	1,611.9	3	220.9

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**БЭЛТГЭСЭН:**

“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК-ИЙН

АУДИТОР:

**ХЯНАСАН:**

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

ЗАХИРАЛ

**АНХАН ШАТАНД ХЯНАСАН:**

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

**ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:



Л.БААСАНДОРЖ

Огноо: 2022.2.25

М.БЯМБАДОРЖ

Огноо: 2/25

Б.БАЙГАЛ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Ц.НАРМАНДАХ

Огноо: